

*Д.Энхбаяр - ХСИС-ийн Удирдлагын академийн
Цагдаагийн удирдлага, стратегийн профессорын багийм ахлах
багш, цагдаагийн дэд хурандаа*

СТРАТЕГИЙН ТАГНУУЛЫН ҮЙЛ АЖИЛЛАГАА, ТҮ ҮНД ХИЙХ ШИНЖИЛГЭЭ

Хураангуй: Цагдаа, хууль сахиулах байгууллагаас гэмт хэрэгтэй тэмцэхэд стратегийн тагнуулын үйл ажиллагаа явуулах түүнчлэн мэдээ мэдээлэлд дүн шинжилгээ хийх онцлогийн талаар гадаад орны туршлага болон судлаачийн байр суурийг илэрхийлсэн болно.

Төлхөөр угс. Стратегийн тагнуул, гүйцэтгэх тагнуулын ажил, эрүүгийн цагдаагийн алба, дүн шинжилгээ (анализ), эрсдэл, мэдээ мэдээлэл, гүйцэтгэх ажлын дүн шинжилгээ, эрсдэлийн дүн шинжилгээ (риск анализ).

Гэмт хэрэгтэй тэмцэхээс илүү чухал зүйл бол түүнийг гарахаас нь өмнө таслан зогсоож, урьдчилан сэргийлэх үйл ажиллагаа юм. Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажилд (ГХУСА) Эрүүгийн цагдаагийн албаны гүйцэтгэх тагнуулын ажлын хүрээг өргөжүүлэн, стратегийн тагнуулын үйл ажиллагааг Монгол Улсын нутаг дэвсгэрийн хэмжээнд албан ёсоор авч хэрэгжүүлэх шаардлага зүй ёсоор урган гарч байна. Цагдаагийн байгууллагын ГХУСА гүйцэтгэх ажлын мэдээлэлгүйгээр, тэр тусмаа сайн стратегийн тагнуулын үйл ажиллагааны мэдээлэлгүйгээр бүрэн гүйцэд хийгдсэн гэх үндэслэл бага юм.

Стратегийн тагнуулын үйл ажиллагааг сэтгэхүйн, бодит мэдээллийг боловсруулах үйл явцыг шинжлэх ухааны түвшинд аваачин хөгжүүлсэнтэй холбоотойгоор урган гарч ирж бий болсон гэж үздэг.

Тодорхой бүс нутагт гэмт хэрэг гарах магадлал үндэр байна гэсэн мэдээлэл нь тухайн цаг үеийн нөхцөл байдлын тухай ерөнхий мэдээлэл юм. Харин тухайн бүс нутагт байгаа орчин, хүн амын бүтэц, онцлог, тархалт насны болон амьдралын түвшин. гэмт хэрэгт холбогдогсдын талаар нарийвчилсан судалгааг урт удаан хугацааны туршид явуулан, гэмт хэрэг үйлдэх эрмэлзэл бүхий этгээдүүдийн үйлдлийг урьдчилан харж, энэ тухай хэрэгжүүлэх шатны алба хаагчдад олдсон мэдээллээ цаг тухайд нь үгч, уг мэдээллийн дагуу ГХУСА-ыг үндэс суурьтайгаар зохион байгуулснаар стратегийн тагнуулын үйл ажиллагааны мэдээлэл ач холбогдлоо үгч эхэлнэ.

Стратегийн тагнуулын Үйл ажиллагааны Үндсэн хэсгийг нийгмийн шинжлэх ухаан эзэлдэг. Энэ Үйл ажиллагаа нь гүйцэтгэх ажилтнуудын цуглуулсан мэдээлэл болон түүнд дүн шинжилгээ хийгчдийн шинжлэх ухааны үндэслэл бэхий логик дүгнэлт, тодорхой судалгаан дээр үндэслэн нэгдсэн дүгнэлт хийх зэрэг Үйл ажиллагаанууд дээр тулгуурласан тасралтгүй, урт хугацааны Үйл ажиллагааг шаарддаг. Сүүлийн үед техник технологийн хөгжил, нийгмийн сонирхол, мэдээллийн технологийн өсрөнгүй хөгжил ч стратегийн тагнуулын Үйл ажиллагаанд өсрөлт гаргасан. Гэхдээ бидний ойлгох гэж оролдож учрыг нь тайлах гэж тэмцэж байгаа гэмт хэрэг, хэдий чинээ бүрхэг. Өргөн цар хүрээг хамарч байлаа ч дүн шинжилгээ хийдэг хүний оюун ухааны орон зайг техник технологи хэзээ ч нөхж чадахгүй.

Стратегийн тагнуулын Үйл ажиллагаа нь түүрийн бодлогыг тодорхойлох, албан тушаалын хүмүүсийг мэдээллээр хангах үндсэн зорилготой, тагнуулын байгууллагын Үйл ажиллагааны нэг хэлбэр боловч уг чанартаа бэхий л байгууллага цаашдын бодлого, зорилтоо хэрэгжүүлэхийн тулд энэ Үйл ажиллагааг их бага хэмжээгээр явуулж байдаг. Гэмт хэрэгтэй тэмцэх, түүнээс урьдчилан сэргийлэх Үйл ажиллагаанд оновчтой Өр дүнтэй алхмуудыг хийхийн тулд стратегийн тагнуулын Үйл ажиллагаа онцгой чухал ач холбогдолтой юм.

Аливаа зүйлс, Үйл ажиллагааны талаар тодорхой мэдээллийг олж авахын тулд хийж байгаа судалгаанууд нь тухайн мэдээллийн мэдрэхүйн түвшин дэх нөхцөлийн Өр дүн юм. Жишээ нь айлын эхнэр дэлгүүр гарч худалдаа хийхдээ, эмч Өвчтнүүд эмчлэхдээ хийх гэж байгаа Үйлдэлтэйгээ холбоотой мэдээлэлд анхаарлаа хандуулдаг. Нэндээ энэ нь дэндүү доод мэдрэхүйгээс гарч ирдэг, хүний энгийн Үйл хүдлэл учраас тагнуулын мэдээлэл цуглуулах Үйл ажиллагааны хүрээнд тэр болгон авч үздэггүй.

Доод мэдрэхүйгээс ч бай, түүрийн хүсэл эрмэлзэл, судалгааных ч бай тагнуулын Үйл ажиллагааны зорилго нь хамгийн зөв шийдэлд хүрэх явдал мөн. Тэгвэл стратегийн тагнуулын Үйл ажиллагаа нь энэхүү ач холбогдол бэхий мэдээлэлд хүрэх Өөр нэгэн оролдлого юм.

Гэхдээ стратегийн тагнуулын Үйл ажиллагаатай холбогдох маш олон салбар бий. Хэрэв стратегийн тагнуулын Үйл ажиллагаа явуулж байгаа бол юуны түрүүнд энэ мэдээлэл очих хүмүүс маш тодорхой. онц чухал гэсэн тодотголтой хүмүүс байх хэрэгтэй. Яагаад гэвэл энэхүү мэдээллийг зөв ойлгож, зөв бодлого хэрэгжүүлэх хэмжээний мэдлэг боловсрол бэхий бодлого тодорхойлох шатны хүмүүс байхгүй бол буруу дүгнэлт. буруу ойлголт шийдвэр нь шууд улсын аюулгүй байдалд нөлөөлөх аюултай. Стратегийн тагнуулын Үйл ажиллагааны энэ хэсгийг

нь аливаа улс тусгаар оршихын тулд шаардлагатай зүйл гэж нэрлэвэл. Үйл ажиллагааны хэсэг нь улсыг бэхэлд нь нэг цогц болгон харах боломжийг бүрдүүлж өгдөг бөгөөд энэ нь алхах алхам бүрт тэнцвэрийг хангах гол түшиг болно.

Үүний дараа улсын хэмжээнд хндрэл гаргаж байгаа асуудлуудыг шийдвэрлэхийн тулд, зөвхөн үүрийн орны хэмжээнд биш гадаад орнуудтай холбоотой урт удаан хугацааны судалгаа, таамаглалыг дэвшүүлэн ажиллах шаардлага түрхийн зэрэгцээ, бидний хэрэгжүүлэхээр зорьсон үйл ажиллагаа, бодлогод бусдын зүгээс ямар хариулт ирэх магадлалтай байгаа, үүнийх нь эсрэг байж болох боломж болгон дээр ямар хариуг бид барих вэ гэсэн асуултуудын хариултыг олоход стратегийн тагнуулын үйл ажиллагаа чухал. Мэдээж энэхүү чухал систем хөдөлгөөнд орж, зөв дүн шинжилгээ хийж, зөв мэдээллээр хангахын тулд, энэ чиглэлээр мэргэжсэн ажилтнууд маш чухал. Яагаад гэвэл нийгмийн үзэгдэлд, болж өнгөрч буй үйл явдлуудтай холбоотой тухайн үед авч хэрэгжүүлж байгаа арга хэмжээнүүдийн тухай мэдээлэл болон жинхэнэ бодит байдал хоёрын хоорондын холбоог тогтоон судалж, болж өнгөрч буй үйл явдалд шууд дүгнэлт өгч, үнэхээр харагдаж байгаа шигээ зүйл мөн үү, эсвэл үдүүн хатгасан, тараан бутаргах зорилго бүхий, хорлон сөйтгэх үйл ажиллагаа юу гэдгийг тусгай дүн шинжилгээ хийх арга тактикаар боловсруулан зөв дүгнэлтийг хийж чаддаг боловсон хүчин онцгой чухал юм.

Стратегийн тагнуулын үйл ажиллагаа нь маш олон салбарыг хамрах судалгаа дүгнэлтийг хийдэг учраас асар их хүдөлмөр, ажлын зөв хуваарилалтыг шаарддаг. Стратегийн тагнуулын үйл ажиллагаанаас ирэх мэдээлэл ч мөн л олон асуудалд хариулт өгөх шинж чанартай байдаг бөгөөд дайны цагт хэдэн мянган хүний бүрэлдэхүүнтэй баг бүрэлдэж байж л сая бага багаар урагшлан давших боломжийг бий болгосон жишээ байдаг. Энхийн цагт бол энэ тоог багасгаж яагаад ч болохгүй гэж эрдэмтэд үздэг.

Түрүүр хэлбэл аливаа салбар стратегийн тагнуулын үйл ажиллагаанд тулгуурлан үйл ажиллагаа явуулахаар шийдсэн бол үүрийн бүтэц, үйл ажиллагааны чиглэлийг мэдэх мэргэжлийн алба хаагчдыг энэ ажлыг гүйцэтгүүлэхээр хангалттай тоо хэмжээгээр бүрдүүлж, удирдлага зохион байгуулалтыг зөв хийж өгөх шаардлагатай.

Тагнуулын үйл ажиллагааны зорилго нь амжилттай үйл ажиллагаа явуулах хамгийн зөв алхмыг тогтоох явдал мөн. Тэгвэл стратегийн тагнуулын үйл ажиллагаа нь аливаа үйлдэл хийх этгээдэд зөв үед, зөв газар байх боломжийг бүрдүүлж өгдөггүйр онцлог юм. Гэхдээ үйл

ажиллагааг хэрэгжүүлэхэд хэдий эв алхмыг, эв цаг өд хийлээ ч ард түмэнд буруу ойлголт түрж, түрл бүрийн эсэргүүцэлтэй тулгарах боломжийг ч үйл ажиллагаандаа тооцох хэрэгтэй юм.

Эрүүгийн цагдаагийн газар энэ утгаараа ГХУСА-д гүйцэтгэх ёстой гол үүрэг нь стратегийн тагнуулын ажиллагаа явуулах мэргэжлийн түвшний дүн шинжилгээ хийх судлаачдаас бүрдсэн багийг бүрдүүлж ажиллах нь юун түрүүнд хийгдэх ёстой чухал ажил юм.

Нийгмийн шинжлэх ухааны салбар дахь бүхий л салбаруудтай нягт харилцан ажиллах хууль эрх зүйн орчинг судлаж ажиллах нь энэ чиглэлд хийх ул суурьтай алхамуудын эхлэл болж үгн. Цаг өөийн байдал, хэвлэл мэдээллийн хэрэгслүүдийн дүн шинжилгээ, үйлчлэгчийн сэтгэл дундуур явдаг зүйлс, орон байрны гэрэлтүүлэг, хог хаягдлын асуудал гэх мэтээс эхлээд бүхий л салбарт хүрч, тэдэнтэй харьцаж ажиллах шаардлагыг бий болгох энэ ажлаас гарах нэгдсэн дүн шинжилгээний дүгнэлт ГХУСА-ыг үр дүнтэй хэрэгжүүлэх ажлын үндсэн гол эх сурвалж нь болж, улмаар алдаа мадаггүй, хамгийн бага зардлаар, үндэрт үр дүнтэй алхамуудыг хийх боломжийг бий болгоно.

Гэмт хэрэг гэсэн ерөнхий ойлголтыг ярьж байгаа боловч угтаа хууль зүрчлүн бүхий л үйлдлүүдтэй холбоотой дүн шинжилгээ судалгаа хийгдэх шаардлагатай учраас энэ ажилд салбар болгоныг хамарсан, мэргэжлийн хүмүүсээс бүрдсэн баг ажиллаж байж үр дүнтэй анализ хийж, дүгнэлт гарган хамгийн бодитой хувилбараар таамаглалыг дэвшүүлэх боломжтой болно.

Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх үйл ажиллагааны тухай яриа нь гэмт хэрэг үүсэх болсон шалтгааны гинжин хэлхээний бодит эхлэлд хүрч түүнийг нь таслан зогсоох тухай асуудал юм гэж дүгнэж үзвэл энэ асуудал гэмт хэрэгтэй тэмцэхээс илүү хүнд ачааг цагдаагийн байгууллага үүрэх шаардлага бий болсон тухай энд яригдаж байгаа юм гэсэн сэтгэгдэл түрж байна. Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг Монгол Улсын цагдаагийн байгууллага нэр түртэйгээр биелүүлж ирсэн гэдэгт хэн ч эргэлзэхгүй. Гэхдээ хангалттай биелүүлсэн үү, гэдэг асуултанд хэдий хэмжээний стратегийн тагнуулын үйл ажиллагаа явуулав гэдгээр нь л хариулт үгч чадах байх. Олон жил гэмт хэрэгтэй тэмцэж, гэмт хэргийн ойлголт суусан, дадлага туршлага үндэр, тухайн газар нутгийг сайн мэддэг гэж бид ажилтнуудынхаа талаар дүгнэн хэлэх дуртай байдаг. Тэгвэл стратегийн тагнуулын үйл ажиллагаа явуулахгүйгээр дээр дурьдагдсан сайн шижийг бүрэн цогцлуулсан, ажилтнуудаас бүрдсэн, гэмт хэргээс урьдсан сэргийлэх ажлын баг гэмт хэргээс тодорхой хугацаанд л урьдчилан сэргийлж чадах байх. Нэг хоёр жилдээ тоон

Зөвлөлтэд ахиц гарах ч яваандаа энэ байдал эргээд сүргээр нөлүүлж, улам боловсронгуй, мэргэжлийн чиг хандалагатай олон олон гэмт хэргийг үргэлжлэн бий болгоход хүргэнэ. Учир нь тэд криминологич шиг хэргийг бүрэн задлан шинжилж чадахгүй. сэтгэл зүйч шиг гэмт хэрэгтний сэтгэл зүйг ойлгож чадахгүй, нийгэм судлаач шиг тухайн иргэйн нийгмийн чиг хандлагыг мэдэрч чадахгүй, багш сурган хүмүүжүүлэгч шиг насныхны сонирхлыг ойлгохгүй. Харин энэ бүхнийг үргэлж агуулсан эсвэл тэдэнтэй нягт хамтран ажилладаг стратегийн тагнуулын баг тухайн асуудлыг авч судалснаар нэгдсэн дүгнэлтийг хийж, хамгийн оновчтой таамаг дэвшүүлэн, тухайн албаны ажил иргэйн хуваарилалтын оновчтой байдлаас авахуулаад урьдчилан сэргийлэх ажлын үр дүнг байнгын болгох, цаашилбал бүрэн таслан зогсоож, хэвлэл мэдээллийн хэрэгслийг ашиглан, тэдгээрээс хийгдэх мэдээллийг хүртэл боловсруулан нийгмийг зөв эрүүл сэтгэхүйтэй болгох боломжийг бүрдүүлнэ.

Статистик мэдээллийн алба, 4 дэгч засаглал буюу хэвлэл мэдээллийн хэрэгсэл, эдийн засгийн мэдээлэл олгох салбар, нийгмийн бэлхийл салбарыг хамарсан, иргэний бүтэц, тархац байршил зэргийн талаар мэдээлэл өгөх албад, татвар, хил, гааль, эмнэлэг, боловсролтойн салбар зэрэг нь стратегийн тагнуулын албаны үндсэн хоол нь юм.

Цаг өтөй холбоотой мэдээ мэдээллийг үдэр, долоо хоног, сар, улирал тутамд нэгтгэн, хийгдэх шаардлагатай ажил төрлийн эрсдэл зэргийг тооцон урьдчилан сэргийлэх ажлын бодлогыг тогтоож, эрх бэлхий албадад хүргүүлэн, хэрэгжүүлэх шатны албадыг мэдээллээр бүрэн хангаж өгөх нь Эрүүгийн цагдаагийн газрын ГХУСА-ын хүрээнд хийх стратегийн тагнуулын үйл ажиллагааны үүрэг мөн.

Энэ ажил эхлэн явагдаж голдиролдоо ортол хэрэгжүүлэх шатны албад ч үүрсдийн чиглэлээр үйл ажиллагаагаа явуулан гэмт хэргээс урьдчилан сэргийлэх үйл ажиллагаагааны тасралтгүй байдлыг хангах нь зүйтэй. Харин мэдээ мэдээлэл ирж эхэлсэн үеэс үйл ажиллагааныхаа бодлогыг боломжийн хирээр уян хатан байлгаж, явцын дунд бүрэн уялдуулж ажиллах шаардлагатай. Ингээд цагдаагийн байгууллага гэмт хэрэгтэй холбоотой хийгддэг дүн шинжилгээний талаар ерөнхий ойлголтыг өгье.

Дүн шинжилгээ

Орчин иргэйн ертөнц бүрэлдэн бий болж, хуучин цаг иргэйн гэмт хэрэгтэй тэмцэх арга барилд үргэлжлэлт гарсаар байна. Иргэрсний цаг өд гэмт хэрэгтэй тэмцэх нь одоогийнхтой харьцуулахад арай амар хялбар байсан гэж хэлж болно. Мэдээлэл харилцааны техник хэрэгсэл төдийлэн хөгжсөнгүй, гэмт хэрэгтнийг толгой эргүүлэн олон төрлөөр үүр

хоорондоо харилцаж, дэлхийг хэрсэн том сүлжээнүүд бий болгох явдал бага байсан зэрэг нь гэмт хэрэг маш нарийн зохион байгуулалттай үйлдэгдэх боломжийг хязгаарлаж байлаа.

Өргөлж хэрэгээ тэлж байгаа нийгэмд гэмт хэргийн гаралт өсч, үйлдэгдэж байгаа гэмт хэргийн арга барил улам нарийсч байгаа нь гэмт хэргийн бүрэлдэхүүнийг хялбар ойлгогдохоор тайлбарлах шаардлагыг зүй ёсоор бий болгож байна.

Энэ утгаараа орчин үеийн хөгжлийн нэг үзүүлэлт болон хөгжсөн дүн шинжилгээний аргаар гэмт хэрэг, гэмт хэрэгтэн хоёрын хоорондын холбоог тогтоох, болзошгүй эрсдэлийг шинжлэх ухааны үндэслэлтэйгээр гарган тайлбарлах, дүн шинжилгээний үр дүнд бий болсон мэдээллийг хамгийн хялбар ойлгогдох хэлбэрээр, олон улсын стандартад тохирох шаардлагыг ханган тайлбарлах хэрэгтэй болсон гэдгийг бидэнд харуулж байна.

Дүн шинжилгээний үндсэн зорилго нь гэмт хэрэг, гэмт хэрэгтний хань харилцаа, түүнд холбогдох бусад зүйлсийг хамгийн энгийнээр тайлбарлах юм. Гэмт хэрэг үйлдэгдэх арга хэлбэр нь нарийсч, гэмт хэрэгтнүүд хоорондын хань харилцаа, ой ухаан тогтохын аргагүй болтол томорсон нь түүнтэй тэмцэж байгаа хүмүүст хүндрэл учруулж, гэмт хэрэг, гэмт хэрэгтний хоорондын холбоо, тодорхой үйл явдал хоорондын цаг хугацааны уялдаа холбоог тогтоох хэцүү болж байгаа ч дүн шинжилгээ хийх аргаар энэ бүхнийг мэргэжлийн дүн шинжилгээний ажилтнууд мэдлэг туршлагаа ашиглан яв цав тогтоодог.

Судалгаа хийж байгаа цагдаагийн алба, өөрийн хийж байгаа судалгааны талаар хангалттай хэмжээнд мэдээлэлтэй болж асуудалд өөрийн байр сууринаас бүрэн хандаж чадаж байлаа ч энэ мэдээллээ улсын дээд бодлого тодорхойлох албадад гүйцэд бүрэн гүйцэд ойлгомжтой байж чадахгүй байх магадлалтай. Дүн шинжилгээ хийж байгаа арга тактикийн бас нэг гол зорилго нь энэ үл ойлгогдох байдлыг арилгах юм.

Нүүдэл дэлхийд дүн шинжилгээг гэмт хэргийн дүн шинжилгээ, гүйцэтгэх ажлын дүн шинжилгээ, эрсдэлийн дүн шинжилгээ гэж 3 хуваадаг.

1. Гэмт хэргийн дүн шинжилгээ, гүйцэтгэх ажлын дүн шинжилгээ, эрсдэлийн дүн шинжилгээ хэмээх ухагдахуун

Гэмт хэргийн дүн шинжилгээ, гүйцэтгэх ажлын дүн шинжилгээ, эрсдэлийн дүн шинжилгээ гэсэн ухагдахуунууд нь өөр хоорондоо ижил төстэй ойлгогддог ухагдахуунууд юм.

Гэмт хэргийн дүн шинжилгээ нь гэмт хэргийг илрүүлэх зорилгоор болон криминологийн чиглэлээр хийгдэж байгаа үйл ажиллагаанууд.

гэмт хэргийн холбогдолтой зүйлс, тэдгээрийн хоорондын холбоог тогтоож, тодорхойлдог. Үүрээр хэлбэл гэмт хэргийн дүн шинжилгээ хийхэд гэмт хэрэг гарсан байх шаардлагатай. Харин гүйцэтгэх тагнуулын ажлын дүн шинжилгээ гэмт хэрэг гарсан байх шаардлага заавал тавигддаггүй. Энэ утгаараа гүйцэтгэх тагнуулын ажлын дүн шинжилгээ нь гэмт хэргийн болон урьдчилан сэргийлэх чиглэлээр холбогдох материал. Гүгдлүүд, үүр бусад мэдээ, мэдээллүүд хоорондын уялдаа холбоог судалж тодорхойлдог гэж тайлбарладаг. Эрсдэлийн дүн шинжилгээ харин, ирээдүйд бий болж болох, асуудал үүсэх магадлалыг судалж, болзошгүй аюулын дохиог тогтоон, үүнд шаардлагатай урьдчилан сэргийлэх арга хэмжээ авахад хэрэглэгддэг. Энэ утгаараа эрсдэлийн дүн шинжилгээ нь болзошгүй асуудлуудыг урьдчилан тооцоолж, идэвхитэй байдлаар дүн шинжилгээ хийх зорилготой ажил юм.

Эрсдэл болон тодорхойгүй байдал хоёр нэг нэгэндээ их ойрхон, зарим тохиолдолд нэг нэгэнд нь орлуулаад хэрэглэгчидхдэг явдал заримдаа гардаг. Шийдвэр гаргах механизм ирээдүйд болох үйл явдалтай холбоотой гарч болох магадлал бүхий үр дүнгүүдийг урьдчилан мэдэж байдаг бөгөөд энэ магадлалуудтай холбоотой боломжуудыг тодорхойлж чадахгүй тохиолдолд тодорхойгүй байдал энд байна гэсэн үг. Харин үйл явдалтай холбоотой бий болж болох бүхий л таамаглалууд биелэж болох тухай таамаглалыг дэвшүүлж чадах чадамжийг эрсдэлийн дүн шинжилгээ (риск анализ) гэж нэрлэдэг.

Эрсдэлийн дүн шинжилгээ нь стратегийн ач холбогдол бүхий шийдвэр гаргахад, судалж байгаа асуудлын эрсдэлийг хамгийн ойлгомжтой хэлбэрээр тайлбарладаг арга, үйл ажиллагааны нэгдэл юм. Үүрээр хэлбэл сонирхол татаж байгаа зүйлтэй холбоотой таамаглал, магадлалыг график хэлбэрээр гаргаж үр дүнгээ илтгэн тавьдаг. Харин магадлалын графикийг бий болгоход үүр үүр арга, хэрэгсэл, техник ашиглагддаг байна.

Сүүлийн 30-40 жил судлаачид гэмт хэрэг, гэмт хэрэгтэн хоёрын хоорондын хамаарлыг хэмжээний хувийн үйл ажиллагааны гүйцэтгэх үүрэг, гэмт хэрэг бий болоход нөлөөлөх нөлөө, гэмт хэрэг, гэмт хэрэгтний профилыг бий болгоход анхаарах хэрэгтэй зүйлс, гэмт хэрэг төрлийн байдал, ажил хийж байгаа хэмжээс, хувь хэмжээний харилцааны хэлбэр гэх мэт зүйлсийг илүү анхааран судалж байна.

Гэмт хэргийн дүн шинжилгээний ач холбогдол нь терроризм, хар тамхи, авто машин хил дамнуулан хулгайлах зэрэг зохион байгуулалттай гэмт бэлэглэлүүдэд хамаарах төрөл бүрийн үйл ажиллагаа, хулгайлах, булаах үйлдэл хийж байгаа сэжигтнүүдийг, эсвэл алуурчныг олж

тодорхойлох гэх мэт Үндэр төвшний гэмт хэргийн бэтгэц, зохион байгуулалт, хувь хэмжээг гаргах зорилготой хэрэглэгддэг арга, Үйл ажиллагаагаар илэрдэг.

Үндсэн арга техник нэг стандарттай болсон, бүр цаашилбал харахад л ойлгогдох хэмжээнд аваачсан мэргэжлийн хүний Үйл ажиллагаа нь бүх л хүн ойлгоход хялбар болгосон гэсэн үг юм.

Эрсдэлийн дүн шинжилгээг ихэвчлэн нийгмийг аюулаас хамгаалах Үйл ажиллагаанд хамгийн Үндэр хэмжээнд ашиглах хэрэгтэй гэж үздэг хүмүүс сүүлийн үед олширч байна.

Нийгэмд маш том аюул заналыг бий болгож байгаа. Мун иргэд хохирч болох Үйл ажиллагаанд аюулгүй байдлыг хангах үүрэг хүлээсэн албад болох цагдаа, тагнуулын байгууллагуудад дүн шинжилгээ хийх боломжийг бий болгох, эсвэл хийгдсэн дүн шинжилгээг Үйл ажиллагааньтхаа хэрэгжилтэнд ашиглах, эсвэл бүр мөсөн уг Үйл ажиллагаанаас урьдчилан сэргийлэхэд эрсдэлийн дүн шинжилгээ нь маш Үндэр ач холбогдолтой.

Дүгнэлт

Стратегийн тагнуул хэмээх ойлголт нь илүү тагнуулын төв аппарат. Үндэсний аюулгүйн зөвлөлтэй холбоотой ухагдахуун боловч цаашид цагдаа, хууль сахиулах байгууллагад энэ салбарыг хөгжүүлэхээс үүр зам үлдээгүй гэдэг нь харагдаж байна. Газар орон болгонд л тэмцэл жагсаал цуглаан, нийгмийг эмх замбараагүй байдалд оруулах, уруу татах Үйл ажиллагаа үргэлж, хэвлэл мэдээллийн хэрэгслийн хараат бус шударга байдал алдагдаж байгаа нь нийгмийг чиглүүлэгч механизм үүрүүр ажиллаж эхлэх, энэ бүхнийг урьдчилан харж төлөлтэй тэмцэх бодлогоо зөв төлөвлөх нь цагдаа, хууль сахиулах байгууллагуудын цаашдын Үйл ажиллагааны зорилго байх ёстой.

Ирээдүйд зөрчилгүй, амгалан тайван нийгэмд амьдрах нь иргэдийн чин хүсэл, харин улсын бусад салбарт гарсан доголдуудыг улс төрийн гэмт хэргийн болон ашиг сонирхлын зорилгоор ашиглах боломжийг бид нэг алхмын үүднээс харж, зохицуулж чадах чадвартай байх хэрэгтэй.

Үүний тулд дараах саналыг дэвшүүлж байна. Үүнд:

1. Цагдаагийн байгууллага тэр дундаа Эрүүгийн цагдаагийн албанд дүн шинжилгээ хийх мэргэшсэн ажилтнуудыг дотоод ба гадаадын сургуулиар бэлтгэн гаргах.

2. ХСИС-ийн Удирдлагын академийн “Цагдаагийн удирдлага” хичээлийн хүтлөлтөрт энэ төрлийн хичээлийг хүтлөлтөрт төлөвлөгөөтэйгээр оруулан заах.

З.Алтангэрэл - ХСИС-ийн Хууль сахиулахын удирдлагын академийн 8032 дугаар дамжааны суралцагч, цагдаагийн дэд хурандаа

Ю.Бадамханд - Хууль сахиулахын удирдлагын академийн Цагдаагийн удирдлага, стратегийн профессорын багийн дэд профессор, хууль зүйн ухааны доктор (Ph.D). цагдаагийн хурандаа

ЦАГДААГИЙН УДИРДАХ АЛБАН ТУШААЛТНЫ МАНЛАЙЛАЛД ХИЙСЭН ДЭМЖИЛГЭЭ, ТӨННИЙГ ДЭЭШЛЭЛЭХ АРГА ЗАМ

“Эрх барих амархан, удирдах хэцүү”

И.В. Гёте

Хураангуй. Тус илтгэлээр манлайллын тухай ойлголт, төрлийн мөн чанар, хэрэгцээ, шаардлагыг тодорхойлох, цагдаагийн удирдах албан тушаалтны манлайлах чадварын төрлийн байдалд дэмжиншилгээ хийж, улмаар төрлийг дээшлүүлэх арга замыг эрэлхийлэхийг зорьлоо.

Төлхөөрөг. Манлайлал, удирдлага, цагдаагийн албан, удирдах албан тушаалтан, ур чадвар, цагдаагийн алба

Аливаа байгууллагын үйл ажиллагааны амжилт, ололт зөв менежмент, сайн удирдагчаас шууд хамаарах ба энэ ч утгаараа удирдах албан тушаалтны манлайлалыг дээшлүүлэх, тэдний мэргэжлийн ёс зүйг төлөвшүүлэх нь хамгаас чухал бөгөөд энэ нь цаашдаа байгууллагын хөгжлийн гол үндсийн нэг болдог. Төргөөр ч зогсохгүй нөөдөр "тогтвортой менежмент, шинэлэг, бэтгэлч сэтгэлгээ байгууллагын хөгжил, дэвшилд амжилт авчрах гол эх үүсвэр болно" гэж үзэх болжээ.

Удирдах албан тушаалтны ур чадвар, удирдлагын арга барил, манлайллыг шинжлэх ухааны онолын үүднээс судлан тайлбарлах, улмаар төрлийн мөн чанарыг тодорхойлох, цаашлаад манлайлалыг бий болгох, хөгжүүлэх тухай асуудлыг авч үзэхийн тулд эхлээд “манлайлал” гэх ерөнхий ухагдахуун, ойлголтыг зөв танин мэдэх, ойлгохоос эхлэх учиртай.

Хэл бичгийн тайлбар толь бичигт: манлайлал (англ. leadership, орос. лидерство) - ажил үйлс, үг яриа, үйл хөдлөллөрөө бусдад үлгэрлэх, тэднийг дагуулах үйлдэл’ гэж тайлбарлажээ.

Нийтийн соёл, танин мэдэхүйн талаас авч үзвэл:

Манлайлал - аливаа хөний бусдад нөлөөлөх чадвар ба үмнүү тавьсан зорилго, зорилтыг хэрэгжүүлэх хөсэл, тэмүүлэл төрүүлэх урлаг¹ гэж

¹ Б.Одбаатар. Байгууллагын удирдлага: онол, арга зүй. - УБ., 2015. 11 дахь тал.